



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/506

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.11, 14.1.14 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Батлан хамгаалахын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын журам”-ыг хавсралт ёсоор баталж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

2.Журмын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Батлан хамгаалах яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Зэвсэгт хүчний Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Батлан хамгаалахын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын журам батлах тухай” А/295 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч (бригадын генерал Ж.Болдбаатар)-д даалгасугай.

САЙД



Д.БАТЛУТ

1325100983

Батлан хамгаалахын сайдын 2025 оны
12 дугаар сарын 25-ны өдрийн
А/506 дүгээр тушаалын хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХЫН ДОТООД АУДИТ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Батлан хамгаалахын төсвийн ерөнхийлөн захирагч болон Зэвсэгт хүчний төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын зорилго, хамрах хүрээ, чиглэл, үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, улсын (ахлах) байцаагчийн эрх, үүрэг болон оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Батлан хамгаалахын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын зорилго нь Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, салбар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Цэргийн штаб, харьяа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, удирдлагыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.3. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, эрх бүхий албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэх ээр гаргасан эрх зүйн баримт бичиг болон энэхүү журмыг удирдлага болгоно.

1.4. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, олон улсын стандартад заасан арга, хэлбэрээр хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах, үнэн зөв, бодитойгоор үнэлж, дүнг шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчмыг баримтална.

Хоёр. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын хамрах хүрээ

2.1. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг батлан хамгаалахын төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Зэвсэгт хүчний төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж эрхлэн явуулна.

2.2. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын нэгжүүд нь дараах анги, байгууллагуудад хяналт шалгалт хийнэ:

2.2.1. Батлан хамгаалахын төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын нэгж нь Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах газар, нэгтгэл, анги, салбар, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб;

2.2.2. Зэвсэгт хүчний төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх санхүүгийн хяналт шалгалт /дотоод аудит/-ын нэгж нь Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл,

анги, байгууллагуудад тус тус хяналт шалгалт хийнэ.

Гурав. Батлан хамгаалахын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын чиглэл.

3.1. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна:

3.1.1. Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэр түүнд нийцүүлэн эрх бүхий албан тушаалтны баталсан эрх зүйн баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, дүрэм, журам, заавар, норм, стандартын мөрдөлт;

3.1.2.Бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, уялдаа холбоо, хэрэгжилт;

3.1.3.Анги, байгууллагын стратегийн зорилго, зорилт, чиг үүрэг, үндсэн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт;

3.1.4.Анги, байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааны үр дүн;

3.1.5.Анги, байгууллагын даргын тушаалаар томилогдсон тодорхой чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа, шийдвэр гаргасан байдал;

3.1.6.Төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсвийн хөрөнгийн зарцуулалт;

3.1.7.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, ашиглалт, зарцуулалт, үр дүн;

3.1.8. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж олох орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, зарцуулалт, ашгийн байдал;

3.1.9.Төрийн өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, тооллогын чанар, үр дүн, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт;

3.1.10.Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;

3.1.11.Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, авлага, өглөгийн байдал, санхүүгийн тайлан гаргалт;

3.1.12.Бие бүрэлдэхүүний цалингийн тооцоолол, олголт;

3.1.13.Цэргийн материал, техник, цэргийн алба хаагчдын ахуй хангалт, төвлөрсөн болон төвлөрсөн бус хангалтаар бэлтгэн нийлүүлэгдсэн бараа материалын төсөв, санхүүжилт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа;

3.1.14.Батлан хамгаалах материаллаг нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, шинэчлэлт, зарцуулалт;

3.1.15.Засгийн газрын тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж, дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын

байгууллага, гадаадын орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн бүртгэл, тооцоо, ашиглалт, зарцуулалт, үр дүн;

3.1.16. Олон улсын болон хоёр талын хамтарсан сургалт, дадлагын санхүүжилт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа;

3.1.17.Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт;

3.1.18.Холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмаар байгууллагын удирдлага, албан тушаалтнуудын төрийн өмч, эд хөрөнгийн хариуцлагатай холбоотой үүргийн биелэлт;

3.1.19. Шилэн дансны тухай хууль, холбогдон гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, нэгдсэн цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээлэл байршуулсан байдал;

3.1.20. Хөндлөнгийн болон дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт;

3.1.21.Удирдлагын шийдвэрээр болон байгууллага, иргэдээс өмч хөрөнгө, санхүү төсвийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдол, үндэслэл бүхий мэдээллийн мөрөөр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх.

Дөрөв. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын
үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

4.1.Батлан хамгаалахын төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын нэгж нь анги, байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлд суурилсан “Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө” болон “Дотоод аудитын жилийн төлөвлөгөө”-г боловсруулж, Батлан хамгаалахын дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж, батлуулна.

4.2.Зэвсэгт хүчний төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн хяналт шалгалт /дотоод аудит/-ын нэгж нь энэхүү журмын 4.1-д заасан төлөвлөгөөтэй уялдуулан жилийн төлөвлөгөөг боловсруулах, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар батлуулна.

4.3.Анги, байгууллагад санхүүгийн хяналт шалгалтыг 2 жил тутам нэгээс доошгүй удаа хийнэ. Дотоод аудит хийх давтамжийг эрсдэлийн үнэлгээг харгалзан тогтооно.

4.4.Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын нэгжүүд нь тайлант жилийн төлөвлөлтийн уялдааг хангах, хяналт шалгалтын ажлыг давхардалгүй зохион байгуулан хэрэгжүүлнэ.

4.5.Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийг тухайн анги, байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн, хяналт шалгалтын зорилго, хамрах хүрээ, чиглэлийг тодорхойлж, боловсруулан Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга тус тус батална.

4.6. Дотоод аудит хариуцсан албан тушаалтан, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч хяналт шалгалтыг шалгуулагч этгээд, эсхүл төлөөлөх эрх бүхий албан тушаалтныг байлцуулан хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд, тогтоосон хугацаанд бүрэн гүйцэд хийнэ.

4.7. Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч хяналт шалгалтыг хяналтын хуудсаар хийх, шалгуулагч этгээдийн хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартын сахин мөрдөлтийн түвшинг тогтооно.

4.8. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэлд дурдсан асуудлаар төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийхдээ гомдол гаргагч болон эрх ашиг нь хөндөгдөж байгаа талуудын санал, хүсэлт, тайлбарыг авч, хариуг хуулийн хугацаанд холбогдох талуудад хүргүүлнэ.

4.9. Батлан хамгаалахын төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын нэгж нь Зэвсэгт хүчний төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн хяналт шалгалтын нэгжийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

4.10. Шалгалтад хамрагдаж буй байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, төсөв, өмч хөрөнгийн хэмжээнээс хамааран дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт явуулах хугацааг "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт"-д заасны дагуу дараах байдлаар тогтооно.

4.10.1. Төрийн өмчит томоохон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, жилд 5.0 тэрбум төгрөгөөс дээш санхүүжилттэй төсөвт байгууллагад - ажлын 30 хоног;

4.10.2. Төрийн өмчит жижиг, дунд хэмжээний аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, жилд 1.0- 5.0 тэрбум хүртэл төгрөгийн санхүүжилттэй төсөвт байгууллагад - ажлын 25 хоног;

4.10.3. Бага хэмжээний буюу жилд 1.0 тэрбум хүртэл төгрөгийн санхүүжилт авдаг төсөвт байгууллагад - ажлын 14 хоног.

4.11. Хяналт шалгалтын явцад зайлшгүй нөхцөл байдал тогтоогдвол энэ талаарх үндэслэлээ хяналт шалгалтын удирдамж баталсан албан тушаалтанд танилцуулж, хугацааг 30 хүртэл хоногоор сунгуулах болон бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.

4.12. Хяналт шалгалтын явцад мэргэжлийн байгууллага, тухайн хяналт шалгалтад хувийн ашиг сонирхолгүй тусгай мэдлэг бүхий хүн, шинжилгээ хийх эрх авсан шинжээч, төрийн байгууллагад ажиллаж байгаа тусгай мэдлэг бүхий албан хаагчаар дүгнэлт гаргуулж болно.

4.13. Дотоод аудит хариуцсан албан тушаалтан, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцдаа шалгуулагч этгээдийн эрсдэлийн ангиллыг танилцуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар тухайн шалгуулагч этгээдийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг таниулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар зөвлөн тусална.

4.14.Шалгуулагч этгээдийн зүгээс хяналт шалгалтын ажилд саад учруулах, шаардлагатай баримт материалыг гаргаж өгөхгүй байх, хяналт шалгалтын дүнг хүлээн зөвшөөрөөгүй нь хяналт шалгалтыг зогсоох, хойшлуулах үндэслэл болохгүй.

4.15. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын ажлын баримт, шалгалтын тэмдэглэл, төсөвт болон төрийн өмчит аж нэгж байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг хоёр хувь үйлдэх бөгөөд нэг хувийг шалгуулагч этгээдэд өгнө. Дотоод аудитын ажлын баримт, санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэл үйлдэхдээ холбогдох стандартыг мөрдөнө.

4.16.Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавих, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах зорилгоор албан шаардлага үйлдэнэ.

4.17.Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч нь шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал гэмт хэргийн шинжгүй бол Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.12.2-т заасны дагуу төсөвт болон бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтооно. Тухайн зөрчлийг улсын байцаагч илрүүлсэн тохиолдолд улсын ахлах байцаагчид шилжүүлэх, дахин шалгасны үндсэн дээр улсын ахлах байцаагч төлбөрийн акт тогтооно.

4.18.Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч шалгалтаар төсөв, төрийн өмч хөрөнгөнд их хэмжээний хор хохирол учирсан, гэмт хэргийн шинжтэй зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд удирдлагад танилцуулах, шалгалтын акт, холбогдох баримт бичгийг хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

4.19. Энэхүү журмын 4.17, 4.18-д заасан захиргааны акт үйлдэхдээ Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу сонсох ажиллагаа явуулж, шалгуулагч байгууллагын холбогдох этгээдийг тайлбар, санал гаргах боломжоор хангана. Сонсох ажиллагааны мэдэгдэл, тэмдэглэл, тайлбар, саналыг баримтжуулан шалгалтын тэмдэглэлд хавсаргана.

4.20.Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт дууссанаас хойш ажлын 7 хоногийн дотор дотоод аудитын тайлан, ажлын баримт, шалгалтын тэмдэглэл бичиж, хариуцсан бүтцийн нэгжийн даргад танилцуулна.

4.21.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжийн дарга нь дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын шалгалтын дүнг Батлан хамгаалахын сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж, яамны Батлан хамгаалахын дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлнэ.

4.22.Зэвсэгт хүчний төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн хяналт шалгалт (дотоод аудит)-ын нэгж нь хяналт шалгалтад хамрагдсан анги, байгууллагын шалгалтын дүнг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ. Шаардлагатай гэж үзвэл Батлан хамгаалахын дотоод аудитын хорооны хурлаар тухайн асуудлыг хэлэлцүүлэн, шийдвэрлүүлж болно.

4.23. Батлан хамгаалахын дотоод аудитын хорооны хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

4.23.1.Батлан хамгаалахын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын дунд хугацааны болон жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явц;

4.23.2.удирдлагын шийдвэрээр дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын дүн;

4.23.3.хөндлөнгийн болон дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар хүргүүлсэн акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явц;

4.23.4.шалгалтад хамрагдсан анги, байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд анхаарах асуудал, цаашид авах арга хэмжээ, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох санал.

4.24. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын нэгж нь хяналт шалгалтаар тогтоосон акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж, Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний удирдлагад танилцуулна.

4.25. Зэвсэгт хүчний төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн хяналт шалгалт (дотоод аудит) хариуцсан нэгж үйл ажиллагааны тайлан, тоон мэдээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан загварын дагуу гаргаж, Батлан хамгаалах яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжид хагас жилийн тайланг 07 дугаар сарын 05, бүтэн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хүргүүлнэ.

4.26. Батлан хамгаалахын төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хагас, бүтэн жилийн тайлан, тоон мэдээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 07 дугаар сарын 10, дараа жилийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Тав. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын ажлын баримтжуулалт, хадгалалт

5.1.Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдалтай холбоотой нотлох баримт, шалгуулагч байгууллагын тайлбарыг баримтжуулах, дотоод аудитын ажлын баримт болон шалгалтын тэмдэглэлд хавсаргана.

5.2.Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хариуцсан албан тушаалтнууд нь анги, байгууллагын чиг үүрэг, үндсэн үйл ажиллагаа, төсөв, өмч хөрөнгийн цар хүрээ, дотоодын болон хөндлөнгийн хяналт шалгалтын дүн, зөрчил, дутагдал, авсан арга хэмжээний талаар мэдээллийн нэгдсэн санг хөтлөх, тухай бүр баяжилт хийнэ.

5.3.Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, нэг бүрчилсэн акт, албан шаардлага, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг зохих стандартын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн, архивд хүлээлгэн өгнө.

5.4.Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч нь дотоод аудит, хяналт

шалгалт хариуцсан албан тушаалтнуудыг чиг үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

Зургаа. Бусад байгууллагатай харилцах

6.1.Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын нэгж нь төрийн аудит болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай дараах хүрээнд хамтран ажиллаж болно.

6.1.1.дунд хугацааны стратеги, жилийн ажлын төлөвлөгөө, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлангийн талаар мэдээлэл солилцох;

6.1.2.хамтарсан сургалт зохион байгуулах, үйл ажиллагааны арга зүй, туршлага судлах;

6.1.3.бусад үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцох.

Долоо. Шалгуулагч байгууллагын удирдлага, албан тушаалтны үүрэг

7.1.Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг явуулах үед шалгагч нарын шаардсан мэдээ, материал, лавлагаа, тайлбарыг хяналт шалгалт, аудит хийлгэж байгаа анги, байгууллага, хуулийн этгээдийн удирдлага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хугацаанд нь гаргаж өгөх, шаардлагатай тохиолдолд сонсох ажиллагаа, санал асуулгад оролцох.

7.2.Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй, дотоод хяналт шалгалтыг сулруулсан, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн, төсвийн сахилга зөрчсөн, төрийн өмч хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй албан тушаалтнуудад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцох саналыг удирдах дээд шатны байгууллагад хүргүүлэх, авсан арга хэмжээг яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлалын хүний нөөцийн бүртгэлд бүртгэн, тэдний албан ажлыг дүгнэх, албан тушаалд дэвшүүлэн томилох, шагнаж урамшуулах, сургууль дамжаанд сургахаар сонгохдоо нэг үндсэн үзүүлэлт болгох, шударга ёсны зарчмыг баримтлах үүрэг хүлээх.

7.3.Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан анги, байгууллагууд шалгалтын дүгнэлт, санал, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд гаргах, хяналт шалгалтыг хийсэн байгууллагад тайлагнах.

7.4.Төсөв, санхүүгийн сахилга, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, зөрчил, дутагдлыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр бие бүрэлдэхүүнд хууль, дүрэм, журам, зааврыг сурталчлан таниулах, дотоод хяналтыг тогтмолжуулах, үр нөлөөг дээшлүүлэх.

Найм. Бусад зүйл

8.1.Шалгуулагч байгууллага, албан тушаалтан нь санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн гаргасан акт, албан шаардлага, шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол Улсын Сангийн сайд буюу

санхүүгийн хяналт шалгалтын улсын ерөнхий байцаагчид гомдол гаргаж болно.

8.2. Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдон гарсан гомдлыг шалгалтын дүн, акт, албан шаардлагын талаар мэдэгдэж гарын үсэг зуруулснаас хойш 30 хоногийн дотор Санхүүгийн хяналт шалгалтын ерөнхий байцаагчид гаргаж, шийдвэрлүүлнэ.

8.3. Дотоод аудитын ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, байцаагч нь хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан бол түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.4. Хяналт шалгалтын нэгжийн албан тушаалтнууд хөдөө, орон нутагт байрлах Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэхээр томилогдон ажилласан тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу албан томилолтыг зардлыг нөхөн олгоно.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ